

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Дүрэм, дүрмийн зорилт

- 1.1 Энэхүү Иргэдийн Оролцооны Нэгдэл намын дүрэм (цаашид “**Намын дүрэм**” гэх)-ийг Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон холбогдох бусад журамтай нийцүүлэн боловсруулж, дүрмийн төсөлд Намын үүсгэн байгуулагч гишүүдийн саналыг авч улмаар ИОНН үүсгэн байгуулах хурлаар танилцуулж, баталсан болно.
- 1.2 Намын дүрмээр Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд тус намд элсэх, намын гишүүнээс түдгэлзүүлэх, гарах, гишүүдийн эрх үүргийг тогтоох, намын үйл ажиллагааг удирдах бүтэц зохион байгуулалтыг байгуулах, намын үйл ажиллагааг төлөвшүүлэх хийгээд хийгээд намын дотоод бүртгэл, гишүүний татвар, хандив, дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл нам нь (цаашид ИОНН эсхүл Нам гэх)
 - 1.3.1 Тодорхойлолт: Иргэний Оролцооны Нэгдэл нам нь Монгол улсын тусгаар тогтнол, бие даасан урт хугацааны тогтвортой хөгжлийг иргэдийн идэвхтэй оролцоо, эрх, эрх чөлөөний тусламжтайгаар буй болгож баталгаажуулахыг зорьж буй, баруун төвийн үзэл санааг баримталсан Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн чөлөөт, сайн дурын нэгдэл юм.
 - 1.3.2 Намын албан ёсны нэрийг бүтнээр “Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам” гэх ба “ИОНН” гэж товчилно. Англиар “The Civic Unity Party” гэх ба “CUP” гэж товчилно.
 - 1.3.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл намын бэлгэдэл нь мөнх тэнгэрийг харуулсан цэнхэр дэвсгэр дээр Монгол орны дөрвөн зүг, найман зовхисоос иргэд эрх чөлөөтэй, эвлэлдэн нэгдэж эх орондоо хөгжил дэвшил авчирч, дээшлэн дэвшиж байхыг цагаан өнгийн гар гараасаа хөтлөлцсөн найман хүний дүрээр харуулж, иргэдийнхээ идэвхтэй оролцоогоор өнөд хамгаалагдаж бэхжих тусгаар тогтнол, төрт ёс, хууль ёсыг төвдөө алтан тойрогт залрах соёмбо тэмдгээр илэрхийлэн дүрсэлсэн байна.
 - 1.3.4 Иргэдийн Оролцооны Нэгдэл намын далбаа нь хэмжээнийхээ гуравны нэгийг эзэлсэн төв хэсэгт ИОНН-ын бэлгэдлийг багтаасан цэнхэр өнгөтэй байна. Далбааг хэвтээ болон босоо хэлбэрээр хэрэглэж болох бөгөөд аль ч тохиолдолд бэлгэдлийн төв хэсэгт байрлах алтан соёмбо нь дээш харсан байна.
 - 1.3.5 Намын домэйн нэр нь www.cup.mn байна.
- 1.4 Намын нэр, далбаа, бэлгэдэл, домэйн нэр нь холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн буюу баталгаажсан даруйдаа намын оюуны өмч болно. Тэдгээрийн эх загварыг энэхүү Дүрмийн Хавсралт 1-д заав.

- 1.5 Нам нь өөрийн бэлгэдлийг дүрсэлсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр болон бэлгэдэл бүхий лого, тэмдэгтэй барина.
- 1.6 Энэхүү Намын дүрэмд үндэслэн Намын дүрэм хэрэгжүүлэх аргачлалыг Төлөөлөгчдийн Танхим батална.
- 1.7 ИОНН нь дүрмээ баррель үсгээр хэвлүүлнэ. Сонсдог хэлбэрээр нийтэлнэ.
- 1.8 Энэхүү дүрмийн аль ч зүйл хэсгийг мушгин тайлбарлахгүй бөгөөд дараах хэм хэмжээний дэс дарааллыг баримтална. Үүнд:
 - 1.8.1 Зарчим;
 - 1.8.2 Намын дүрмийн тухайлсан зохицуулалт;
 - 1.8.3 Намын дүрэм хэрэгжүүлэх аргачлал.

2 дугаар зүйл. Намын үзэл баримтлал, үнэт зүйл.

- 2.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам нь баруун төвийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэгч нам болохын хувьд дараах үнэт зүйлтэй байна. Үүнд:
 - 2.1.1 Монгол Улсын аюулгүй байдал, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол бол ИОН намын нэн тэргүүний язгуур үнэт зүйл мөн.
 - 2.1.2 Ардчилал, олон намын тогтолцоо, парламентын засаглал, хүний эрх, эрх чөлөө нь ИОНН-ын тууштай хамгаалах ёстой үнэт зүйл мөн. ИОНН нь Монгол Улс цаазаар авах ялыг халах бодлогыг тууштай дэмжинэ.
 - 2.1.3 Хувийн өмч, хувийн хэвшил нь улс орны эдийн засгийн хамгийн тогтвортой бат бэх үндэс бөгөөд эдийн засгийн чөлөөт байдалд төрийн оролцоо хязгаарлагдмал байх бодлогыг баримтална.
 - 2.1.4 Үндэсний өв соёлоо хамгаалж судлах, өвлөн тээх, дамжуулан уламжлуулах, орчин үеийн Монгол үндэсний бахархал, соёлыг бүтээлцэх нь ИОНН-ын гишүүн бүрийн эрхэмлэх үнэт зүйл мөн.
 - 2.1.5 Ил тод байдал, иргэний оролцоо, хэмнэлттэй байдал, ёс зүйн стандарт нь ИОНН-ын гишүүн бүрийн болон намын үйл ажиллагааны үнэт зүйл мөн.
 - 2.1.6 Хуулийн засаглалыг хөгжүүлэн бэхжүүлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, улс орны тогтвортой хөгжлийг бий болгох, Монгол оронд хүн шударгаар ажиллаж амжилтад хүрч, аз жаргалтай амьдарч болох хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох нь бидний үнэт зорилт мөн.
 - 2.1.7 Гадаад харилцаанд олон талт, энх тайванч, найрсаг хөршийн бодлогыг тууштай дэмжиж, бусад улс төрийн намуудтай гадаад харилцааны асуудлаар зөрчилдөхөөс сэргийлж, Монгол Улсын нэгдмэл гадаад бодлогыг баталгаажуулах нь намын үнэт зүйл мөн.
 - 2.1.8 Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын суурь үйлчилгээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх, үр нөлөөг дээшлүүлэх, нийгмийн олон талт асуудлаар нийтийн

боловсролыг байнга нэмэгдүүлэх замаар ирээдүйн зардлыг бууруулах нь намын бодлогын чухал хэсэг мөн.

- 2.1.9 Уламжлалт мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, аялал жуулчлал зэрэг олон салбарын суурь нь болсон байгаль орчин, бэлчээр, ус, ой, газрын баялагтай холбоотой аливаа чиглэлд ИОНН тогтвортой хөгжил, хариуцлагатай хэрэглээ, ил тод байдал, нийтийн эрх ашиг - хувийн өмчийн эрхийн тэнцвэртэй харилцаа, ирээдүйд үлдээх нөөц, нөхөн сэргээлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх явдлыг үнэт зүйл гэж үзнэ.
- 2.1.10 Нийгмийн харилцааны бүхий л оролцогчдын хөгжих, хөгжлийн үйл явцад оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэдний амьдрах орчныг эрүүл аюулгүй байдлыг сайжруулах нь ИОНН-ын үнэт зүйл мөн.
- 2.1.11 Нам нь эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эрх, үүрэг, боломж эдлүүлнэ.
- 2.1.12 Үзэл бодлоо илэрхийлэх үйл ажиллагааг зохистой арга хэлбэрээр зохион байгуулж, нийгмийн дэг журам, аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахыг эрхэмлэнэ.
- 2.1.13 Намын дотоод сонгуулийг нээлттэй, тэгш шударга зохион байгуулна.

3 дугаар зүйл. Намын үйл ажиллагааны зарчим

3.1 Нам үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримтална:

- 3.1.1 ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх;
- 3.1.2 үйл ажиллагаагаа ил тод явуулах;
- 3.1.3 гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, аливаа сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох;
- 3.1.4 дотоод асуудлаа шийдэхдээ нийтийн зарыг хүртээмжтэйгээр түгээж, хурал, сонгуульд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх;
- 3.1.5 бусад намын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох, өөрийн үзэл баримтлалыг тулган шаардахгүй байх;
- 3.1.6 үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулах;
- 3.1.7 Монгол Улсаас гадаад улстай тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг эрхэмлэн хүндэтгэх.
- 3.1.8 ИОНН нь оюуны өмч, оюуны бүтээлийг ямагт хүндэтгэн үйл ажиллагаандаа албан ёсны лиценз зөвшөөрөлтэй бараа бүтээгдэхүүн, программ, үйлчилгээг хэрэглэнэ. Үүнд намын хөрөнгөөс зарцуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ авах тухай хуулийн дагуу нээлттэй ил тод зохион байгуулна.

- 3.1.9 ИОНН нь орчин үеийн мэдээллийн технологийн шийдэл, гар утас болон таблетын аппликэйшн, вэбсайт, цахим шууданг өдөр тутмын үйл ажиллагаанд өргөнөөр хэрэглэж, гишүүдийн оролцоог орон зай, газар зүйн байрлалаас үл хамааран хүртээмжтэй зохион байгуулна. Эдгээр технологийг ашиглан гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрнө.

4 дугаар зүйл. Намд элсэх, намаас гарах, түдгэлзэх

4.1 ИОНН нь гишүүдийнхээ өмнө гаргах баталгаа:

- 4.1.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намд эвлэлдэн нэгдсэн, Намын үйл хэргийг олон нийтэд таниулахаар ажилласны төлөө болон гишүүний хувьд иргэнийг мөшгөн хавчих, занал хийх, гүтгэх, доромжлох, дарамтлах зэргээр хууль бус үйлдэл гаргасан бол ИОНН-ын энэ дүрэмд заасан бүтцийн байгууллага, албан тушаалтан гишүүнийхээ эрхийг хамгаалж, мэдэгдэл гаргана.
- 4.1.2 Намын гишүүний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ИОНН намын гишүүн болох талаар тодорхойлолтыг хэнд ч гаргахгүй. Гэхдээ Намын гишүүдэд нээлттэй аппликэйшн, вэбсайт, намын дотоод бүртгэлийн мэдээлэл үүнд хамаарахгүй.
- 4.1.3 Намын гишүүнийг үзэл бодлоо баримтлах, санаа бодлоо илэрхийлэх, улс төрийн өрсөлдөөнд оролцох зэрэг улс төрийн эрхээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан аливаа шийтгэл хүлээлгэхгүй. Намын албан тушаалаас огцруулах, оноогоор дүгнэх, хариуцлага тооцох нь зөвхөн энэ Намын дүрэм, Дүрэм хэрэгжүүлэх аргачлалд заасан хэм хэмжээ, энэхүү дүрэмд заасан шийдвэр гаргах эрх бүхий гишүүдийн олонхын саналаар шийдэгдэнэ.
- 4.2 Монгол Улсын сонгуулийн насны эрх бүхий иргэн сайн дураар ИОННамд элсэнэ. Намд элсэхдээ дараах бүртгэлийн аль ч хэлбэрээр бүртгүүлж болно. Үүнд:
- 4.2.1 Цахим орчинд байрлах Намын албан ёсны вэбсайтын “намд элсэх” холбоосыг ашиглаж бүртгэлийн өргөдлийг зааврын дагуу бөглөж, Намд элсэх өргөдлөө илгээх, эсхүл
- 4.2.2 Өөрийн оршин суугаа газрын байрлалаас үл хамааран намын гүйцэтгэх байгууллага оршин байгаа байранд биеэр ирж бичгээр өргөдөл гаргах.
- 4.3 Цахимаар буюу өөрийн биеэр ирж өргөдөл гаргасны дагуу ИОНН-ын бүртгэгч (цаашид **Бүртгэгч** гэх) өргөдлийг системд оруулан намын аппликэйшн дээр дахин давтагдашгүй хувийн код үүсэж, намын гишүүний цахим профайл үүссэнээр тухайн өргөдөл гаргагч ИОННамд элссэнд тооцогдоно.
- 4.4 Энэ дүрмийн 4.3 -т заасны дагуу намын гишүүнээр бүртгэж авсныг амаар болон өргөдөл гаргагчийн цахим шуудангаар мэдэгдсэнээр, 4.2.1-д заасны дагуу бүртгүүлснийг апп-ын админ тэр даруй баталгаажуулснаар намд элсэнд тооцно.
- 4.5 Өөр намын гишүүнийг ИОНН-д гишүүнээр бүртгэхгүй. Хэрэв Намд шинээр бүртгүүлсэн хүн өөр намын гишүүнээс гарах өргөдлөө тус намын төв буюу, эсвэл орон нутгийн харьяаллын анхан, дунд аль нэг шатны байгууллагад цахимаар илгээх буюу биечлэн хүлээлгэн өгсөн бол тус өдрөөс эхлэн шинээр бүртгүүлсэн хүнийг ИОННамд элссэн гэж үзэн Намын үйл ажиллагаанд оролцох оролцоог гишүүний эрх, үүргийн дагуу тооцно.

- 4.6 ИОННамын гишүүнээр элссэн хүн өөр намын бүртгэлээс хасагдаагүй байгаа нь гарах өргөдлөө өгсөн хүнээс хамаарахгүй нөхцөл байдлаас үүдсэн бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан эвлэлдэн нэгдэх эрхээ өөрийн сайн дураар эдлэх иргэний эрх, эрх чөлөөг үндэслэн ИОННам шинэ гишүүнийг бүртгэж авна. ИОННамаас гарах өргөдөл өгсөн хүнд энэ зарчим бас хамаарна.
- 4.7 Хуульд заасны дагуу төрийн зарим албан хаагчийн намын гишүүнчлэлийг түдгэлзүүлж болно. ИОННамын гишүүн төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдсон өдрөөс намын гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ.
- 4.8 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын гишүүнийг хасах үндэслэлийг эрх бүхий бүтцийн байгууллагаас тогтоосон тохиолдолд Үнэт Зүйлийн Зөвлөлийн шийдвэрийн дагуу Бүртгэгч системээс хасна. Үүнд:
- 4.8.1 Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгын аливаа үйл ажиллагаанд ИОННамын нэр, туг, билэг тэмдгийг ашигласан;
- 4.8.2 Намын аль нэг бүтэц, удирдлагын сүлжээ, гишүүдийн баг бүрэлдэхүүнийг шашны, цэргийн, цэрэгжсэн байгууллага болгохыг завдсан;
- 4.8.3 Фашист үзэл санааг дэмжиж сурталчилсан бол тус тус намаас хасах үндэслэл болно.
- 4.8.4 Дээрх үйлдэлд хуулийн хариуцлага хүлээх бол тухайн асуудал шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ.
- 4.9 Намын гишүүн хэдийд ч сайн дураар Намаас гарч болно. Намаас гарахдаа:
- 4.9.1 Намын албан ёсны вэбсайтын “намаас гарах” холбоосыг ашиглаж өөрийн гараар бичсэн өргөдлийг илгээх, эсхүл
- 4.9.2 Оршин суугаа газрын байрлалаас үл хамааран намын албан ёсны хаяг бүхий аль ч байранд биеэр ирж гараар бичсэн өргөдлийг гаргана.
- 4.10 Өргөдлийг намын төв болон орон нутгийн аливаа салбарын удирдлагад хүлээлгэн өгснөөр намаас гарсанд тооцогдоно. Намаас гарсан тухай мэдээллийг өргөдөл хүлээн авсан намын хариуцлагатай албан тушаалтан намын мэдээллийн санд тэр даруй оруулахаар Бүртгэгчид илгээх ба зөвхөн Бүртгэгч уг мэдээллийг намын бүртгэлээс хасалт хийнэ.

5 дүгээр зүйл. Намын гишүүн, түүний төрөл

- 5.1 Намын гишүүд өөрийн нэрээр элсэж, өөрийн нэрийн өмнөөс Намын үйл хэрэгт оролцоно.
- 5.2 Намын гишүүн бүр энэхүү Намын дүрмийг зөвшөөрч, дагаж мөрдөх үүрэгтэй.
- 5.3 Намын гишүүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Намын гишүүн санаа бодлоо төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх, чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

- 5.4 ИОННамын гишүүнээр элссэн хэн бүхэн намын “ажиглагч гишүүн” болж болно. Ажиглагч гишүүн нь татвар төлөхгүй байж болно. Ажиглагч гишүүн намын татвар болон хандив өгсөн байдлаараа татвар төлөгч гишүүн буюу хандивлагч гишүүнээр бүртгүүлж болно.
- 5.5 Ажиглагч гишүүн Намын аливаа хурал, зохион байгуулах арга хэмжээнд санал таслах эрхгүйгээр чөлөөтэй оролцож ажиглах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, намын нийт гишүүдийн дунд явуулах судалгаанд саналын эрхтэй оролцох, сонирхлын клуб үүсгэн байгуулах, нэг буюу хэд хэдэн клубт нэгдэх, намын бүх шатны байгууллагаас мэдээлэл авах, намын болон улс төрийн албан тушаалд томилогдох, сонгогдох эрхтэй.
- 5.6 Намын гишүүний тухайн жилийн татвараа төлсөн бол тухайн календарийн жилд “татвар төлөгч” гишүүн байна.
- 5.7 Татвар төлөгч гишүүн нь тухайн календарийн жилд зохиогдох намын аливаа хуралд таслах эрхтэй оролцох, намын дотоод сонгуульд нэр дэвших, намын болон улс төрийн албан тушаалд томилогдох, сонгогдох эрхтэй.
- 5.8 Намын гишүүн нь жилийн татвараас гадна, намын Бүртгэгчид бүртгэлтэй дансанд өөрийн харьяалагдаж буй салбарын байнгын ажиллагааг хангахад зориулж эсхүл босоо тогтолцооны дагуух намын байгууллагад давхар хандивыг жил тутам өгдөг бол “хандивлагч гишүүн” гэж үзнэ.
- 5.9 Хандивлагч гишүүн нь энэхүү дүрмийн 5.7-т заасан гишүүний эрхээс гадна зөвхөн хандивлагч гишүүдийн дунд явагдах санал асуулгад оролцох эрхтэй байна.
- 5.10 Хандивлагч гишүүн бүр татвар төлөгч гишүүн байна ажиглагч гишүүн бүр татвар төлөгч гишүүн байх албагүй.
- 5.11 Намын ажиглагч, татвар төлөгч, хандивлагч гишүүд нь улс төрийн сонгуульд нэр дэвшихээр бэлтгэж буй бол улс төрийн зорилготой хуримтлалын нэрийн данстай байх ба нэрийн хуримтлалын дансаа Бүртгэгчид бүртгүүлсэн гишүүнийг хуримтлал бүрдүүлэгч гишүүн гэнэ. Хуримтлал бүрдүүлэгч гишүүн нь намд өөрийн хуримтлалаасаа жилийн татвар төлсөн бол энэ дүрмийн 5.1-5.3-т заасан эрхээс гадна төрийн сонгуульд нэр дэвшүүлэх намын дотоод сонгууль, шалгаруулалтад нэр дэвших эрхтэй байна.

6 дүгээр зүйл. Намд хориглох зүйлс, Намын гишүүний болон төрийн албан хаагчийн үүргийг зааглах

- 6.1 Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэний намд албадан элсүүлэх болон намаас гарахыг шаардах, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 6.2 ИОНН нь төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцохыг хориглоно.
- 6.3 ИОНН хамт олон дунд хөгжиж төрийн жинхэнэ албан хаагч болсон аливаа ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийг чанд баримтлах бөгөөд албан тушаалынхаа эрх мэдлийг аль нэгэн намын, тэр тусмаа өөрийн харьяалагдаж байсан энэхүү намын эрх ашигт нийцүүлэн ашиглахыг хориглоно.
- 6.4 ИОНН-аас нэр дэвшин сонгогдсон, томилогдсон улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өөрийн албан тушаалын хүрээнд хамаарах албан үүрэг гүйцэтгэхдээ намын эрх

ашгийг хамгаалсан шийдвэр гаргах, сурталчилгаа хийх, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хориглоно.

- 6.5 ИОНН нь шашны байгууллагын үйл ажиллагаанд болон боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаанд оролцохгүй. Гэхдээ Намын гишүүн шашин шүтэх эс шүтэх, эрхээ эрхлэхэд энэ заалт хамаарахгүй.
- 6.6 Хуулиар хориглосон этгээдээс хандив авахыг хориглоно.
- 6.7 Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг, фашист намтай нэгтгэх, нийлэхийг хориглоно.
- 6.8 Намын удирдлага, санхүүгийн албаны дарга, ерөнхий менежер, түүнтэй адилтгах албан тушаалтан нь аль нэгэн улс төрийн сан, нийгэмлэг, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн нөөц захиран зарцуулах эрх бүхий албан тушаал эрхлэхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НАМЫН ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ТӨЛӨВШҮҮЛЭХ ҮЕ ШАТ

7 дугаар зүйл. Нам үүсгэн байгуулах, дотоод соёл төлөвшүүлэх, салбар байгуулах

- 7.1 Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Үүсгэн байгуулах хурлаар ИОННамыг үүсгэн байгуулж, дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрийг батална. Үүнд:
 - 7.1.1 Намын дүрэм,
 - 7.1.2 Мөрийн хөтөлбөр.
 - 7.1.3 Намын төлөөллийн төв байгууллагын /Төлөөлөгчдийн Танхим/ -ын 25 ба түүнээс доошгүй тооны бүрэлдэхүүн;
 - 7.1.4 Хяналтын байгууллага Маргаан таслах комиссын 7 ба түүнээс доошгүй тооны бүрэлдэхүүн;
 - 7.1.5 Намын дарга.
- 7.2 Дээр дурдсан удирдах болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнээс энэхүү Намын дүрмийг ИОНН үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 18 сарын хугацаанд хасах өөрчлөлт оруулахгүй.
- 7.3 Намын анхан шатны салбар байгуулахыг хүссэн гишүүн тухайн орон нутагт байнга оршин сууж буй гишүүдийн нэрсийн жагсаалтыг, дунд шатны салбар байгуулахыг хүссэн сум, хорооны салбарын дарга тухайн орон нутагт байгуулагдсан анхан шатны салбаруудын даргын нэрсийн жагсаалтыг тус тус Бүртгэгчээс авч, үүсгэн байгуулах хурлын байр, өдөр, цагийг танхимаар хуралдах бол ажлын 3 хоногоос, цахимаар хуралдах бол 24 цагаас багагүй хугацааны өмнө нийт гишүүдэд хүргэнэ.

7.4 Дараах шаардлагыг хангасан бол дор дурдсан субъект нутаг дэвсгэрийн харьяаллаар намын салбарыг байгуулж болно. Үүнд:

7.4.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын сум, хорооны салбарыг тухайн орон нутагт 15-аас доошгүй тооны намын гишүүн байгаа бол үүсгэн байгуулагчдын хурлаар дараах нууц санал хураалтыг явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

7.4.1.1 Намын сум, хорооны салбар байгуулах;

7.4.1.2 Намын сум, хорооны салбарын даргыг сонгох;

7.4.1.3 Сум, хорооны Танхимын гишүүдийг сонгох;

7.4.1.4 Намын сум, хорооны салбарын албан ёсны байрны хаягийг батлах;

7.4.2 Салбар байгуулсан хурлын тогтоолыг сонгогдсон анхан шатны салбарын дарга намын Бүртгэгчид хаяглан ирүүлнэ. Бүртгэгч нь салбар үүсгэн байгуулах хүсэлтийг нягталж, салбарыг албажуулах тухай тушаалын төслийг Намын даргад уламжилна.

7.4.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын аймаг, дүүргийн салбарыг тухайн аймаг, дүүргийн харьяа сум, хорооны гуравны нэгээс доошгүйд нь салбар үүсгэн байгуулсан бол аймаг, дүүргийн салбар байгуулах хурлыг анхан шатны салбаруудын дарга, мөн салбар бүрээс тэнцүү тоотой, тухайн салбарын гишүүдээс нууц санал хураалтаар сонгогдсон бүрэлдэхүүний оролцоотойгоор, аль нэг санаачлагч сум, хорооны салбарын дарга удирдан зохион байгуулж, уг хурлаар дараах асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Үүнд:

7.4.3.1 Аймаг, дүүргийн салбар байгуулах;

7.4.3.2 Аймаг, дүүргийн салбарын даргыг сонгох;

7.4.3.3 Аймаг, дүүргийн Танхимын гишүүдийг сонгох;

7.4.3.4 Аймаг, дүүргийн Танхимын албан ёсны байрны хаягийг батлах;

7.4.4 Салбар байгуулсан хурлын тогтоолыг сонгогдсон дунд шатны салбарын дарга намын Бүртгэгчид хаяглан ирүүлнэ. Бүртгэгч нь салбар үүсгэн байгуулах хүсэлтийг нягталж, салбарыг албажуулах тухай тушаалын төслийг Намын даргад уламжилна

7.4.5 Намын дарга нь сум, хороо, аймаг, дүүргийн салбарыг албажуулах тушаал гаргана.

7.4.6 Намын гишүүд нутаг дэвсгэрийн харьяалал үл харгалзан нийгэмд тулгамдсан асуудлыг Намын үнэт зүйлийн хүрээнд шийдэл гаргах замаар шийдвэрлэхээр нэгдэж, тодорхой сэдвийн хүрээнд сонирхлын бүлэг, клуб байгуулан ажиллаж болох бөгөөд тэдгээрийг Намын дарга албажуулахгүй.

7.4.7 Аливаа хурал, сонгуулийг явуулахдаа гишүүдийн хувьд газар зүй байрлал, ажил, амьдралын хэмнэлийн янз бүрийн нөхцөл байдлыг, оролцоог хүртээмжтэйгээр зохион байгуулна.

7.4.8 Намыг үүсгэн байгуулах хурлаас Төлөөлөгчдийн Танхимын бүрэлдэхүүнийг батлах шийдвэр гарснаас хойш Төлөөлөгчдийн Танхим даруй хуралдаж дараах сонгуулийг зохион байгуулна:

7.4.8.1 Үнэт зүйлийн Хорооны гишүүдийг 9 ба түүнээс доошгүй гишүүнтэйгээр сонгох

7.4.8.2 Бүртгэгчийг сонгох

7.4.8.3 Ерөнхий менежер томилох.

7.4.9 Намын дүрмийг Улсын дээд шүүх бүртгэн авснаас хойш нэг сарын дотор Төлөөлөгчдийн Танхим хуралдаж Дүрэм хэрэгжүүлэх зааврыг батална.

8 дугаар зүйл. Намын байр, ажлын алба

- 8.1 Нам байгуулагдсанаас хойш 18 сарын дотор намын ажлын алба, үйл ажиллагааг жигдрүүлэн зохион байгуулж, дотоод соёлыг төлөвшүүлэх, намын байр, веб сайт, дотоод харилцаа холбооны апп зэрэг дэд бүтцийг нэвтрүүлэх ажлыг намын дарга, салбарын үйл ажиллагааг жигдрүүлэх ажлыг намын салбарын дарга тус тус хариуцна.
- 8.2 Намын болон түүний салбарын нэр дээр үл хөдлөх хөрөнгө худалдан авахыг хориглоно.
- 8.3 Салбарын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах цахим болон харилцаа холбооны бусад арга хэрэгслийг гишүүн бүрд хүртээмжтэй ашиглах боломжтой нөхцөлд намын салбарын үйл ажиллагааг зөвхөн шаардлагатай тохиолдолд түр байранд ажиллах горимоор зохион байгуулж болно.
- 8.4 Нам байгуулагдсанаас хойш 18 сарын дотор намын бүх гишүүдэд нээлттэй, байнгын ажиллагаатай веб сайттай болсон байна. Намын гишүүн аль ч нутаг дэвсгэрээс болон гэрээсээ улс төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг хангана.
- 8.5 Намыг төлөөлж төрийн байгууллагатай харилцах албан харилцаанд намын албан хуудас, тамга ашиглах ба гишүүд, дэмжигчидтэй харилцах албан харилцаанд намын албан ёсны цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон бусад зөвшөөрөгдсөн харилцааны хэрэгслэл ашиглаж болно. Гэхдээ энэ нь үүсэж болох болзошгүй нөхцөл байдалд өөр арга хэрэгслэлээр харилцах харилцааг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.
- 8.6 Намын тамга, албан хуудас гээгдэж үрэгдэх буюу хуурамчаар үйлдэгдэх, цахим хуудас болон цахим харилцааны бусад хэрэгслэл халдлагад өртөх үед зөвхөн намын даргын гарын үсэг бүхий баримт бичгийг гадагш чиглэсэн албан харилцаанд хэрэглэнэ.
- 8.7 Гадаад улс, гадаадын байгууллагатай Нам харилцахад зөвхөн даргын гарын үсэгтэй албан бичиг, даргын албаны цахим шуудан ашиглана. Энэ эрхийг дарга өөрөө хэрэгжүүлэх боломжгүй байвал Намын гадаад харилцаа хариуцсан албан тушаалтанд бичгээр, түр эрх шилжүүлэн өгч болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

НАМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9 дүгээр зүйл. Их Хурал, түүний чөлөөт цагт ажиллах төв байгууллага

- 9.1 Намын эрх барих дээд байгууллага нь Намын Их хурал байна.

- 9.2 Дараах асуудлыг зөвхөн намын Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, батална:
- 9.2.1 Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, бүтэц зохион байгуулалт;
 - 9.2.2 Намын Төлөөлөгчдийн танхим болон Маргаан Таслах Комиссын тайланг хэлэлцэх, тэдгээрийн бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар сонгох;
 - 9.2.3 Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, намын нэрийг өөрчлөх.
 - 9.2.4 Намын даргыг нууц санал хураалтаар сонгох, улируулах, огцруулах;
- 9.3 Намын Их хурлын чөлөөт цагт Намыг Төлөөлөгчдийн танхим удирдана. Төлөөлөгчдийн танхимыг хоёр жил тутамд Намын Их хурлын нууц санал хураалтаар сонгож байгуулна.
- 9.4 Төлөөлөгчдийн Танхим нь намын төлөөллийн төв байгууллага мөн. Төлөөлөгчдийн танхим нь нийтлэг суудалд нэр дэвшиж сонгогдсон 30 эрэгтэй, 30 эмэгтэй, жендер харгалзахгүй 3, аймаг, дүүргийн суудалд тухайн салбар бүрээс нэр дэвшиж сонгогдсон 2 эрэгтэй, 2 эмэгтэй, нийслэлийн суудалд нэр дэвшиж сонгогдсон 5 эмэгтэй, 5 эрэгтэй, нийгмийн бүлгийн төлөөллийн суудалд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 2 эрэгтэй, 2 эмэгтэй (дохионы хэлний орчуулагчийг оруулахгүйгээр), чөлөөт бус суудалд томилогдсон Намын дарга, Бүртгэгч, Ерөнхий менежер нараас тус тус бүрдэнэ.
- 9.5 Энэхүү Намын дүрмийн 9.2-т заасныг үл харгалзан, Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд 30 хүртэлх хувийн өөрчлөлт оруулах асуудлыг Төлөөлөгчдийн Танхим шийдвэрлэж болно.
- 9.6 Намын Төлөөлөгчдийн Танхим нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.6.1 Үнэт зүйлийн зөвлөлийн гишүүдийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх;
 - 9.6.2 Намын Бүртгэгчийг нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх;
 - 9.6.3 Ерөнхий Менежерийг нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх;
 - 9.6.4 Үндэсний хэмжээнд болон аймаг, дүүрэг, нийслэлийн Намын дотоод сонгуулийг зохион байгуулах сонгуулийн төв ажлын хэсэг /тухай бүр/-ийг нууц санал хураалтаар сонгож байгуулах;
 - 9.6.5 Намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 9.6.6 Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын сонгууль, Засгийн Газрын томилгооны үйл явцад нам дангаараа эсхүл өөр намтай эвсэл байгуулж, эсхүл өөр нам эвслийг дэмжиж оролцох эсэх;
 - 9.6.7 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын сонгууль, нөхөн сонгуульд намаас нэр дэвшигчийг нууц санал хураалтаар сонгож батлах;
 - 9.6.8 Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр батлах;
 - 9.6.9 Энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах “Дүрэм хэрэгжүүлэх заавар”, болон дүрмээр тусгайлан заасан журмыг батлах;

- 9.6.10 Жил бүрийн 12 дугаар сарын 31-нээс өмнө дараа жилийн төсвийг баталж, тухайн жилд төлөх гишүүний татварын хэмжээг тогтоох;
- 9.6.11 Маргаан Таслах Комиссын гишүүдийн 30 хүртэлх хувийг дүрмийн 19.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд нөхөн сонгох;
- 9.6.12 Энэхүү дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.

10 дугаар зүйл. Сум, Хорооны Бүх гишүүдийн хурал, Танхим

- 10.1 Сум, хорооны салбарын гишүүдийн хурал нь тухайн засаг захиргааны нэгж дэх намын үйл ажиллагааг удирдана.
- 10.2 Сум, хорооны бүх гишүүдийн хурал жил бүр хуралдаж дараах асуудлыг олонхын саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.
 - 10.2.1 Намын орон нутгийн анхан шатны төлөөллийн байгууллага болох сум, хорооны танхимыг бүх гишүүдийн хурлаас 5-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр, 2 жилийн бүрэн эрхтэйгээр байгуулах, түүний бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөлт оруулах, чөлөөлөх;
 - 10.2.2 Сум, хорооны салбарын даргыг нэг жил хүртэл хугацаагаар сонгох, улируулах, чөлөөлөх;
 - 10.2.3 Сум, хорооны намын болон улс төрийн албанд намаас нэр дэвшүүлэх;
 - 10.2.4 Сум, хорооны түвшинд явагдаж буй төрийн сонгуульд оролцох намын баримтлах мөрийн хөтөлбөрийг батлах;
- 10.3 Сум, хорооны Танхим нь сум хорооны бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт намын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллана. Сум, Хорооны танхимыг сум, хорооны Намын салбарын дарга тэргүүлнэ.
- 10.4 Сум, хорооны Танхим нь улирал тутамд хуралдаж, олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
 - 10.4.1 Сум, хорооны салбарын төсвийг батлах, өөрчлөлт оруулах
 - 10.4.2 Сум, хороонд явагдах дараах дотоод сонгуулийн ажлын хэсгийг байгуулах, бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар батлах;
 - 10.4.3 Намын их хурлын төлөөлөгч, аймаг, дүүргийн Танхимын гишүүнийг нууц санал хураалтаар сонгох;
 - 10.4.4 Намаас улс төрийн албан тушаалд нэр дэвшигчдийг нууц санал хураалтаар тодруулах урьдчилсан судалгаа, санал асуулгыг бүх гишүүд болон хандивлагч гишүүдийн дунд зохион байгуулах;
 - 10.4.5 Сум хорооны салбарын санхүү, үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах
- 10.5 Сум, хорооны Бүх гишүүдийн хурал болон Танхимын гүйцэтгэх алба нь сум, хорооны ажлын алба байна. Ажлын албыг сум, хорооны салбарын дарга, эсхүл түүний томилсон менежер удирдаж болно. Ажлын албанд салбарын даргын томилсон санхүүч байх бөгөөд ажлын албаны данс Намын Бүртгэгчид бүртгэлтэй байна.

11 дугаар зүйл. Аймаг, Дүүрэг, Нийслэлийн Танхим

- 11.1 Аймаг, дүүрэг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй анхан шатны салбарын ажлын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, намын үйл ажиллагааг тухайн дэвсгэрт удирдах үүрэгтэйгээр Аймаг, Дүүрэг, Нийслэлийн Танхим ажиллана.
- 11.2 Аймаг, дүүргийн Танхимын бүрэлдэхүүнийг сонгох сонгуулийн товыг Намын Төлөөлөгчдийн Танхим зарлаж, тухайн сонгуулийг зохион байгуулах төв ажлын хэсгийг байгуулна.
- 11.3 Энэхүү дүрмийн 11.2-т заасан сонгуулийн төв ажлын хэсэг 10.4.2. дахь заалтад заасан сум, хорооны дотоод сонгуулийн ажлын хэсгүүдийг удирдан чиглүүлж, аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын гишүүнийг сонгох сонгуулийг зохион байгуулна.
- 11.4 Аймаг, дүүргийн танхим нь дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдана.
 - 11.4.1 Аймгийн төвөөс бусад сумын салбар тус бүрээс сонгогдсон 1 эмэгтэй, 1 эрэгтэй гишүүн;
 - 11.4.2 Аймгийн төвийн сум, хотын салбараас сонгогдсон 2 эмэгтэй, 2 эрэгтэй гишүүн;
 - 11.4.3 Дүүргийн хороо тус бүрээс сонгогдсон 1 эрэгтэй, 1 эмэгтэй гишүүн
- 11.5 Аймаг, дүүргийн Танхимын шинээр сонгогдсон бүрэлдэхүүний анхны хурлыг аймаг, дүүргийн салбарын дарга, даргыг сонгоогүй, эсхүл хүндэтгэх шалтгаанаар намын ажлаас чөлөө хүссэн, нас барсан, гэмт хэрэг үйлдэж цагдан хоригдсон бол тус тус Намын даргын тушаалаар томилогдсон салбарын даргын үүрэг гүйцэтгэгч товлон зарлаж хуралдуулна.
- 11.6 Нийслэлийн Танхимыг дүүргийн салбарын дарга нар, нийслэлийн танхимын дарга бүрдүүлнэ. Нийслэлийн танхимын даргаар дүүргийн салбарын дарга давхар ажиллахыг хориглоно.
- 11.7 Нийслэлийн Танхимын анхны хурлыг Намын дарга товлон зарлана. Нийслэлийн танхимын анхны хуралдааныг дүүргийн салбарын дарга нарын хамгийн ахмад нь даргална.
- 11.8 Нийслэлийн Танхимын анхны хуралдаанаас дараах шийдвэрийг нууц санал хураалтаар гаргана. Үүнд:
 - 11.8.1 Намын нийслэлийн танхим байгуулах;
 - 11.8.2 Нийслэлийн танхимын даргыг сонгох;
 - 11.8.3 Нийслэлийн танхимын албан ёсны байрны хаягийг батлах.
- 11.9 Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхим нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 11.9.1 Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын даргыг нэг жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, улираах, чөлөөлөх;
 - 11.9.2 Аймаг, дүүрэг, нийслэлийн төлөөллийн байгууллагад намаас нэр дэвшигчийг нууц санал хураалтаар тодруулах;

- 11.9.3 Аймаг, дүүрэг, нийслэлийн түвшинд явагдаж буй төрийн сонгуульд оролцох намын баримтлах мөрийн хөтөлбөрийг батлах;
 - 11.9.4 Аймаг, дүүрэг, нийслэлийн салбарын төсвийг батлах, өөрчлөлт оруулах;
 - 11.9.5 Аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын санхүү, үйл ажиллагааны нэгтгэсэн тайланг хэлэлцэж, батлах
 - 11.9.6 Намаас улс төрийн албан тушаалд нэр дэвшигчдийг тодруулах урьдчилсан судалгаа, санал асуулгыг зохион байгуулах;
- 11.10 Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын гүйцэтгэх алба нь аймаг, дүүрэг, нийслэлийн салбарын ажлын алба байна. Ажлын албыг аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын дарга, эсхүл түүний томилсон менежер удирдаж болно. Ажлын албанд салбарын Танхимын даргын томилсон санхүүч байх бөгөөд ажлын албаны данс ИОНН-ын Бүртгэгчид бүртгэлтэй байна. Аймаг, нийслэлийн салбарын даргын томилсон санхүүч нь сумд, дүүргүүдийн санхүү, үйл ажиллагааны тайланг нэгтгэнэ.

12 дүгээр зүйл. Үнэт Зүйлийн Зөвлөл

- 12.1 Үнэт зүйлийн зөвлөл нь намын өдөр тутмын улс төрийн үйл ажиллагааг эрхлэн явуулах гүйцэтгэх байгууллага мөн.
- 12.2 Үнэт зүйлийн зөвлөлийг нь дараах бүрэлдэхүүнтэйгээр Төлөөлөгчдийн Танхимын гишүүдийн олонхын саналаар 2 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгож байгуулна.
- 12.2.1 40 ба түүнээс дээш насны 5 эмэгтэй, 5 эрэгтэй;
 - 12.2.2 39 ба түүнээс доош насны 5 эмэгтэй, 5 эрэгтэй;
 - 12.2.3 Тусгай хэрэгцээт гишүүдийн төлөөлөл 1 эмэгтэй, 1 эрэгтэй;
 - 12.2.4 Намын дарга.
- 12.3 Үнэт зүйлийн зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 12.3.1 Цаг үеийн улс төрийн нөхцөл байдалд дүгнэлт өгөх, мэдэгдэл гаргах;
 - 12.3.2 Намын дарга, орон нутгийн намын байгууллага, намын ажлын албанд улс төрийн үүрэг, чиглэл өгөх;
 - 12.3.3 Намын Их Хурал, Төлөөлөгчдийн Танхимын эрх хэмжээнд хамаарахаас бусад улс төрийн албан тушаалд намаас нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэх;
 - 12.3.4 УИХ, нийслэл, аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь намын бүлгийн баримтлах улс төрийн байр суурьт чиглэл өгөх;
 - 12.3.5 Энэ дүрмийн 4.8.1-4.8.1.4 дахь заалтын дагуу иргэдээс ирсэн гомдлыг хүлээн авч, хэлэлцэх, шийдвэр гаргах, шийдвэрийг Бүртгэгчид илгээх;
- 12.4 Үнэт зүйлийн зөвлөлийн ээлжит хурлыг Намын дарга, ээлжит бус хурлыг Намын дарга, эсхүл ҮЗЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь гарын үсэг зурснаар зарлан хуралдуулна.

12.5 Үнэт зүйлийн зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэг удаа зарлаж, 12-оос доошгүй гишүүн ирснээр хуралдаж, ирсэн гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

13 дугаар зүйл. Намын Дарга

13.1 Намын дарга нь намыг гадаад, дотоодод төлөөлнө.

13.2 Намын даргыг хоёр жилийн хугацаагаар Намын Их Хурлаас нууц санал хураалтаар сонгох ба намын даргыг 3 хүртэл удаа улируулан сонгож болно. Намын даргын бүрэн эрх дараагийн даргыг намын Их Хурлаар сонгосон тогтоол батлагдсанаар дуусгавар болно.

13.3 Намын дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

13.3.1 Намын Их хурал товлон зарлах, хурлын дарга, тэргүүлэгчдийг санал оруулах;

13.3.2 Төлөөлөгчийн танхим, Үнэт зүйлийн хорооны хурлыг товлон зарлах, удирдах; хурал даргалах эрхийг шилжүүлэх шаардлагатай гэж үзвэл хурлын дарга тэргүүлэгчийг санал оруулах;

13.3.3 Намын нийслэлийн Танхимын анхдугаар хурлыг товлон зарлах;

13.3.4 Намын Ерөнхий менежерийг Төлөөлөгчдийн Танхимаар томилуулахаар санал оруулах;

13.3.5 Намын Үнэт зүйлийн зөвлөлийн бүрэлдэхүүний 51 хүртэлх хувийг Төлөөлөгчдийн Танхимаар сонгуулахаар санал оруулах;

13.3.6 Намын гишүүдийн ойлголцол, эв нэгдлийг хангах, намын хөрөнгө босгох үйл ажиллагаанд манлайлан оролцох;

13.3.7 Намын дотоод аудит, эрсдэлийн удирдлагын багийн хурлыг сар бүр зарлах, сонсголыг удирдах;

13.3.8 Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;

13.4 Намын даргад дараах үйлдлийг хориглоно:

13.4.1 Бүртгэгчид хэн нэгнийг оноож нэр дэвшүүлэх, Төлөөлөгчдийн Танхимын сонгосон Бүртгэгчтэй хамтран ажиллахаас татгалзах, Бүртгэгчийн үйл ажиллагаанд хууль бус шахалт үзүүлэх;

13.4.2 Маргаан Таслах Комиссын бүрэлдэхүүнд хэн нэгнийг нэр дэвшүүлэх, Намын Их Хурал болон Төлөөлөгчдийн Танхимын сонгосон Маргаан Таслах Комиссын болон аль нэг гишүүнийх нь үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх;

13.4.3 Намын санхүү, төсвийг захиран зарцуулах акт баримтад гарын үсэг зурах;

13.5 Энэ дүрмийн 13.4 дэх зүйлд заасан үйлдлийг Намын дарга гаргасан нь түүнийг огцруулах үндэслэл болно.

13.6 Намын дарга дараах нөхцөлийн улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол түүнийг дараагийн намын дарга сонгогдон Улсын дээд шүүхэд бүртгэгдэх хүртэлх хугацаанд Намын ерөнхий менежер түр орлоно. Үүнд:

13.6.1 Нас барсан;

13.6.2 Гэмт хэрэг үйлдэж ял авсны улмаас иргэний эрхээ хязгаарлуулсан;

13.6.3 Намын даргаас огцорсон;

13.6.4 Хүнд өвчний улмаас намын үйл ажиллагаанд нэг жилээс доошгүй хугацаанд оролцох боломжгүй болсныг өөрөө буюу гэр бүлийн гишүүний зүгээс Намын Ерөнхий менежерт хаяглан бичгээр илэрхийлсэн;

14 дугаар зүйл. Намын ерөнхий менежер, ажлын алба

14.1 Намын ерөнхий менежерийг нь намын даргын санал болгосноор Төлөөлөгчдийн танхимаас 2 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгоно. Ерөнхий менежерийг 4 хүртэл удаа улируулан ажиллуулж болно.

14.2 Намын ерөнхий менежер нь намын ажлын албыг зохион байгуулж, удирдах ба намын хөрөнгө, санхүүг захиран зарцуулна.

14.3 Намын ажлын албаны ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажлын байрны тодорхойлолтын дагуу үүрэг хариуцлага хүлээн ажиллана.

14.4 Намын ажлын албаны бүтцэд дараах ажилтан, хэсэг багтах ба ажлын албаны бүтэц, орон тоог Намын дарга батална.

14.4.1 Төлөөлөгчдийн Танхимаар сонгогдсон Бүртгэгч, түүний туслах;

14.4.2 Төлөөлөгчдийн Танхим, Үнэт зүйлийн зөвлөл, Маргааш шийдвэрлэх комиссын нарийн бичгийн дарга;

14.4.3 Санхүүч / Нягтлан бодогч;

14.4.4 Орон нутгийн намын салбар, хэвлэл мэдээлэл, гадаад харилцаа, сургалт судалгаа, мэдээллийн технологийн үйлчилгээ хариуцсан ажилтан;

14.4.5 Санхүү, үйл ажиллагаа, мэдээллийн технологийн, эрсдэлийн удирдлагын ажилтан бүхий дотоод аудит, эрсдэлийн удирдлагын хэсэг.

14.4.6 Намын ерөнхий менежер нь салбарын ажлын албыг нэгдсэн удирдлагаар хангана.

14.4.7 Намын ерөнхий менежер нь Маргаан Таслах комиссыг болон комиссын гишүүдийг тасралтгүй, жигд ажиллах нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулна.

14.4.8 Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг болон намаас байгуулагдсан бусад түр ажлын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангана.

14.4.9 Намын Ажлын алба нь намын нэгдсэн цахим системийг ажиллуулан, уг нэгдсэн цахим системийн тасралтгүй, аюулгүй, найдвартай ажиллагааг хангана.

- 14.4.10 Мэдээллийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж түүнд шаардлагатай удирдлагаар хангаж ажиллана.
- 14.5 Намын ажлын албаны дараа жилийн төсвийг Намын дарга/Төлөөлөгчдийн Танхим жил бүрийн 12-р сарын 10-ны дотор батална.

15 дугаар зүйл. Бүртгэгч

- 15.1 Бүртгэгч нь намын дотоод ил тод байдал, шударга, тэгш байдал, дотоод ардчиллыг хангах чиг үүрэг бүхий сонгуульт, орон тооны, гүйцэтгэх албан тушаал мөн.
- 15.2 Бүртгэгч нь үүрэгт ажлаа гүйцэтгэж байх хугацаандаа намын дотоод сонгууль болон төрийн сонгуульд оролцохгүй.
- 15.3 Бүртгэгч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 15.3.1 Намд элсэхээр бичгээр болон цахимаар өргөдөл гаргасан, апп-аар хүсэлт ирүүлсэн Монгол улсын иргэнийг өөр улс төрийн намд харьяалалтай эсэхийг лавлах, хөндлөнгийн гэрчээс тодруулга авах, батлан даагчаас баталгаа авах замаар нягталж намын гишүүнээр бүртгэн авах;
- 15.3.2 Намын гишүүдийн орон нутгийн болон статусын шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, намын татвар, дотоод сонгууль зохион байгуулагдаж буй саруудад намын гишүүний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг нэг календарийн жилд гурван сараас илүүгүй хугацаагаар зогсоох
- 15.3.3 Намын аливаа дотоод сонгуулийн өмнө саналын эрхтэй гишүүдийн тоо, жагсаалтыг гаргаж дотоод сонгууль зохион байгуулах ажлын хэсэгт нэр дэвшигчийн сурталчилгаа эхлэхээс өмнө хүлээлгэн өгөх;
- 15.3.4 Гишүүдийн бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;
- 15.3.5 Намын татвар, хуримтлал, хандив хүлээн авах данс, тус данснаас гүйлгээ хийх эрх бүхий этгээд, намын албан бичиг, тогтоол шийдвэрт гарын үсэг зурах эрх бүхий этгээд, тамга, тэмдгийн хэв, намын албан ёсны вэбсайт, пэйж, цахим хаягууд, тэдгээрт нэвтрэх эрх эзэмшигч нарын бүртгэлийг тус тус хийж, өөрчлөлт нэг бүрийг шинэчилж байх;
- 15.3.6 Намын дотоод сонгуулиар намын төлөөллийн, гүйцэтгэх, хяналтын байгууллагад болон түр ажлын хэсэгт сонгогдсон, томилогдсон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа эхэлсэн, дууссан огноог бүртгэх;
- 15.3.7 Бүртгэгч нь мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлан шалгахын тулд намын аль ч шатны байгууллага, албан тушаалтнаас тодруулга авах, намын гишүүдтэй ярилцлага хийх, намын цахим дата баазад нэвтрэх эрхтэй байна.
- 15.3.8 Бүртгэгч нь давхардсан, намаас гарахаа илэрхийлсэн, намаас хасах шийдвэр гарсан, бүрэн эрхийн хугацаа дууссан шалтгаанаар аливаа мэдээллийг жагсаалтаас хасахын өмнө “Бүртгэлээс хасах акт”, алдаатай, ташаа орсон мэдээллийг залруулах, статус өөрчлөгдсөн шалтгаанаар бүртгэлд засвар хийхийн өмнө “Бүртгэлд өөрчлөлт оруулах акт” тус тус үйлдэж намын дотоод сүлжээнд нээлттэй мэдээлнэ.

- 15.3.9 Бүртгэгч нь намын хурал, дотоод сонгууль, шалгаруулалттай холбоотой аливаа нийтийн зарыг намын бүртгэлтэй гишүүдэд бүрэн хүргэхэд намын бүх шатны ажлын албанд туслах үүрэгтэй.
- 15.3.10 Бүртгэгч нь эрх, үүргээ хэрэгжүүлэхийн тулд намын ажлын албанаас цалин, ажлын өрөө, тавилга, тоног төхөөрөмж, бичиг хэргийн болон харилцаа холбооны урсгал зардал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах хэрэгсэл, туслах ажилтан гаргуулах авах эрхтэй.
- 15.4 Бүртгэгчийг Төлөөлөгчдийн Танхимаас 4 жилийн хугацаатай 1 хүнийг нууц санал хураалтаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.
- 15.5 Бүртгэгч нь намын гар утас, таблетын апп, вэбсайтын хөгжүүлэлтийн ажил болон цахим бүртгэлийг мэдээллийн технологийн ажилтантай хамтран ажиллана.
- 16 дугаар зүйл. Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг**
- 16.1 Төрийн сонгуульд оролцох Намаас нэр дэвшигчдийг тодруулах болон намын сонгуульд албан тушаалд нэр дэвшигчдийг сонгох дотоод сонгуулийг Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг удирдан зохион байгуулна. Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг нь байнгын бус, орон тооны бус гүйцэтгэх байгууллага мөн.
- 16.2 Намын бүх дотоод сонгууль жил бүрийн 03 дугаар сарын 01-ээс 31-ний хооронд багтан зохион байгуулагдана. Үүнд төрийн сонгуульд намаас нэр дэвшигчийг тодруулах хуулиар заасан хугацаа бүхий дотоод сонгууль хамаарахгүй.
- 16.3 Намын дотоод сонгуулийг зохион байгуулах эрх бүхий дотоод сонгуулийн ажлын хэсгийг дараах этгээдүүд нууц санал хураалтаар, олонхын саналаар байгуулна. Үүнд:
- 16.3.1 Үндэсний, нийслэл, аймаг, дүүргийн сонгуулийн төв ажлын хэсгийг Төлөөлөгчдийн Танхим;
- 16.3.2 Сонгуулийн сум, хорооны ажлын хэсгийг Сум, Хорооны Танхим;
- 16.4 Дотоод сонгуулийн дүнг гарсан даруйд нийтэд мэдээлнэ.
- 16.5 Дотоод сонгуулийн ажлын хэсгийн бүрэн эрх тухайн сонгуулийн дүнг баталсан Ажлын Хэсгийн тогтоолыг сонгуулийн санал авах ажиллагаа дууссанаас хойш гурав хоногийн дотор сонгууль зарласан байгууллагыг төлөөлөх албан тушаалтанд хүлээлгэн өгч, сонгуулийн дүнг Бүртгэгчид илгээснээр дуусгавар болно.
- 16.6 Хэрэв дотоод сонгуулийн талаар маргаан үүсэж, Маргаан Таслах Комисс сонгуулийн дүнг хүчингүйд тооцох зөвлөмж гаргасан бол Ажлын хэсгийг эрх бүхий байгууллага шинээр байгуулж дахин сонгууль явуулна.
- 16.7 Энэ дүрмийн 16.6 дахь заалтын дагуу дахин сонгууль явуулах үр дүн гарсан бол амжилтгүй сонгууль зохион байгуулахад оролцсон ажлын хэсгийн гишүүдийг дахин сонгуулийг зохион байгуулах ажлын хэсэгт оруулахгүй.

16.8 Дотоод сонгуулийн ажлын хэсэгт томилогдон ажиллах хугацаанд нь ажлын байр, урсгал зардал олгох ба гишүүдэд ажлын урамшуулал олгоно. Энэхүү зардлыг баталж, гаргах үүргийг тухайн сонгуулийг зарласан түвшний ажлын алба хариуцна.

17 дүгээр зүйл. Сонгуульд нэр дэвшүүлэх боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах

17.1 Намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулах бөгөөд тус журам нь энэхүү зүйлийн хүрээнд дараах гурван үе шатыг хамран зохицуулалт хийнэ.

17.1.1 Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх үе шат

17.1.2 Тандалт, үнэлгээний үе шат

17.1.3 Хуулиар эрх олгогдсон намын байгууллага шийдвэр гаргах үе шат

17.2 Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх үе шатанд дараах үйл ажиллагаа багтана:

17.2.1 Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний болзлыг ханган Бүртгэгчид бүртгүүлэх;

17.2.2 Төрийн ээлжит сонгуулийн хооронд хамгийн багадаа 1 удаа хандивлагч гишүүнээр бүртгэгдсэн байх;

17.2.3 Намын мөрийн хөтөлбөрт нийцсэн идэвхтэй үйл ажиллагааг зохион байгуулах, манлайлах, нийгэмд танигдах;

17.2.4 Намын үйл ажиллагааны онооны системд хамрагдан босго оноо цуглуулах;

17.3 Тандалт, үнэлгээний үе шатанд дараах үйл ажиллагаа багтана:

17.3.1 Намын дотоод цахим сүлжээнд намын гишүүд болон хандивлагч гишүүдийн дунд санал асуулга явуулах

17.3.2 Нийгмийн сүлжээнд танигдалтын тандалт явуулах

17.3.3 Нэр дэвшихийг хүсэж буй тойрог, сонгогчдын дунд түүвэр судалгаа явуулах;

17.4 Энэхүү дүрмийн 17.2-т заасны дагуу өөрийгөө илэрхийлсэн гишүүдэд хууль сургалт явуулах, намын гишүүдтэй холбогдох хаяг, мэдээллийг тэгш хүргэх үүргийг Намын Ажлын Алба хүлээнэ.

17.5 Намын эрх бүхий байгууллага төрийн сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд багтаж энэ дүрмийн 17.2-т заасны дагуу бүртгэгдсэн гишүүдийн дотроос 17.3-т заасан тандалт, үнэлгээний дүнд үндэслэн нэр дэвшүүлнэ.

17.6 Намаас төрийн сонгуульд нэр дэвшигчдийн дотор эрэгтэй, эмэгтэй аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас багагүй байна.

17.7 Намаас Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших болон Засгийн Газрын гишүүнээр томилогдох хүмүүс дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 17.7.1 УИХ гишүүнд нэр дэвшигч нь УИХ-н сонгуульд оролцох намын мөрийн хөтөлбөртэй холбоотой ядаж нэг хуулийн төсөл ганцаар буюу бусад нэр дэвшигчидтэй хамтран санаачлан боловсруулж Төлөөлөгчдийн танхимаар дэмжүүлсэн байна.
- 17.7.2 Намаас Засгийн Газрын гишүүн сайдаар томилогдон ажиллах хүн хариуцах салбарт хамаарах намын мөрийн хөтөлбөрийг боловсруулахад манлайлан оролцсон байна.
- 17.7.3 Уг дүрмийн 4.11-д заасан шалгалтад амжилттай оролцсон байна.

18 дугаар зүйл. Намын үйл ажиллагааны онооны систем

- 18.1 Үйл ажиллагааны онооны систем нь намын нэгдсэн цахим системийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд намын сонгуульт болон томилогдсон албан тушаалтан, улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүдийн жигд идэвхтэй оролцоог хангах эрсдэлийн удирдлагын механизм мөн.
- 18.2 Намын үйл ажиллагаанд оролцож буй, эс оролцож буй байдлаар намын сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан, улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүдийн дунд онооны системийг мөрдөнө.
- 18.3 Намын үйл ажиллагааны онооны систем нь тоон үзүүлэлтээр хэмжиж болохуйц, тэгш үйлчлэл бүхий, технологид суурилсан байна.
- 18.4 Энэ дүрмийн 18.2 дахь заалтад дурдсан этгээд энэхүү зүйлд заасан онооны системийн үнэлгээнд хамрагдахаас өмнө Ажлын албанаас сургалт авах эрхтэй.
- 18.5 Намын үйл ажиллагааны онооны системийг Төлөөлөгчдийн Танхимын тогтоолоор батлагдсан журмын дагуу Намын Ажлын алба хэрэгжүүлнэ.
- 18.6 Намын үйл ажиллагааны онооны системийн дүнг зөвшөөрөөгүй хүн Маргаан Таслах Комисст гомдол гаргах эрхтэй.

19 дугаар зүйл. Маргаан Таслах Комисс

- 19.1 Маргаан таслах комисс нь намын хяналтын, сонгуульт, хагас орон тооны байгууллага мөн.
- 19.2 Маргаан таслах комисс 15 хүний бүрэлдэхүүнтэй байх ба Намын Их Хурлаас эсвэл түүнээс эрх олгосны дагуу Төлөөлөгчдийн Танхимаас нууц санал хураалтаар сонгогдоно. Маргаан таслах комиссын анхны хурлыг хамгийн ахмад гишүүн удирдан явуулж, гишүүдийн олонхын саналаар тус комиссын даргыг нууц санал хураалтаар сонгоно.
- 19.3 Маргаан таслах комисс цахим болон боломжит хэлбэрээр хуралдана. Маргаан үүсгэсэн нөхцөл байдлыг газар дээр нь баримтжуулах үүргийг маргаан үүсгэгч талууд хариуцах бөгөөд маргаан таслах комисс баримтжуулах, нотлох үйл ажиллагаанд оролцохгүй.
- 19.4 Маргаан таслах комиссын ажиллах журмыг Төлөөлөгчдийн танхимаас батална.
- 19.5 Маргаан таслах комисс нь Монгол Улсын улс төрийн намын тухай хууль, энэхүү дүрмийн хүрээнд ажиллаж маргааныг олонхын саналаар шийдвэрлэнэ. Ингэхдээ хүний суурь эрх, эрх чөлөөнд халдсан асуудал авч хэлэлцэхгүй бөгөөд суурь эрх, эрх чөлөөнд халдсан санал хураалт явуулахгүй. Маргаан таслах комиссын гишүүд энэхүү дүрмийн 16.2-т заасан намын дотоод сонгуулийн үеэр 80 хувиас доошгүй, бусад үед энгийн олонхын бүрэлдэхүүнтэйгээр

ажиллана. Хэрэв намын дотоод сонгуулийн үеэр Маргаан таслах комиссын гишүүд энэ зүйлд заасан хэмжээний бүрэлдэхүүнтэйгээр ажиллах боломжгүй бол Маргаан Таслах Комиссын нөхөн сонгуулийг ээлжит дотоод сонгуулийн сар эхлэхээс гурваас доошгүй хоногийн өмнө Төлөөлөгчдийн Танхим зохион байгуулна.

19.6 Маргаан таслах комисс нь анхан, давж заалдах, хяналтын шатанд дараах бүрэлдэхүүнтэйгээр хуралдана. Үүнд:

19.6.1 Анхан шатны маргаан шийдвэрлэх хурал санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдана.

19.6.2 Давж заалдах шатны маргаан шийдвэрлэх хурал санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 7 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдана.

19.6.3 Хяналтын шатны маргаан шийдвэрлэх хурал комиссын нийт гишүүд буюу 15 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдана. Хяналтын шатны хуралд зөвхөн өмнөх хоёр шатны маргаан шийдвэрлэх процесст алдаа гарсан эсэхийг хэлэлцэнэ.

19.7 Маргаан таслах комиссын анхан ба давж заалдах шатны хурал дараах бүрэн эрхтэй:

19.7.1 Маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх;

19.7.2 Дүгнэлт, зөвлөмж гаргах;

19.8 Маргаан таслах комиссын хяналтын шатны хурал дараах бүрэн эрхтэй:

19.8.1 Анхан ба давж заалдах шатны хурлын шийдвэрийг хянах, хэвээр үлдээх, хүчингүй болгох;

19.9 Маргаан таслах комиссын гишүүдийн ажлын байр, ажлын хөлс, бусад урсгал зардлыг Намын ажлын алба хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НАМЫН САНХҮҮЖИЛТ

20 дүгээр зүйл. Намын хөрөнгө, орлого

20.1 Намын эд хөрөнгөд үл хөдлөх хөрөнгөөс бусад дараах төрлийн эд хөрөнгө байна.

20.1.1 гишүүний татвар;

20.1.2 гишүүн, талархан дэмжигч иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив;

20.1.3 төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;

20.1.4 намын бэлгэдэл, оюуны өмч бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс, намын оюуны өмч шингэсэн бүтээгдэхүүнийг борлуулсан орлогоос ногдох хувь;

20.1.5 намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгаа, сургалтын орлого;

- 20.1.6 өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого;
- 20.1.7 Намын мөнгөн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү.
- 20.2. Нам компани болон бизнесийн бусад байгууллагад хувь эзэмшихгүй.

21 дугаар зүйл. Намын орлогын зарцуулалт

- 21.1 Намын орлогыг зөвхөн намын мөрийн хөтөлбөр, дүрэмд тусгагдсан үйл ажиллагаа явуулахад зарцуулна.
- 21.2 Намын орлогыг өөр зүйлд зарцуулах, гишүүдэд ногдол ашиг болгон хуваарилахыг хориглоно.
- 21.3 Намын үйл ажиллагаанд орлогыг зарцуулахдаа зорилтот үр дүнд хүрэх хамгийн хэмнэлттэй хувилбарыг сонгох зарчмыг баримтална.

22 дугаар зүйл. Гишүүний татвар, намд өгөх хандив

- 22.1 Намын гишүүний жилийн татварыг Төлөөлөгчийн Танхимаас тогтоосон хэмжээгээр, улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний жилийн татварыг өмнөх жилийн нийт хуримтлалын 1 хувиас хэтрэхгүй хэмжээгээр гишүүн өөрөө тогтоож жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор тус тус намын дансанд бүрэн төлнө.
- 22.2 Гишүүн, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намыг дэмжин хандив өргөж болно. Хандивыг зөвхөн тухайн шатны намын салбарын дансаар дамжуулж авна.
- 22.3 Намд зориулж нэг удаа өгөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс арван сая, иргэдээс нэг сая төгрөгөөс хэтэрч болохгүй бөгөөд нэг хандивлагч намын нэг байгууллагад жилд хоёроос олон удаа хандив өгөхийг хориглоно. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 22.4 Нам авсан хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна.
- 22.5 Гишүүний татвар болон хандивыг тооцооны нэг дансанд байршуулна. Энэхүү дансыг намын төв болон салбарын Ажлын Алба намын Бүртгэгчид бүртгүүлж, жил бүр дансанд дотоод буюу эсхүл хөндлөнгийн аудит хийлгэнэ.
- 22.6 Сонгуулийн үйл ажиллагаанд зориулж намд өргөсөн хандивын асуудлыг сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулна.
- 22.7 Дараах этгээдээс хандив авахыг хориглоно:
 - 22.7.1 арван найман насанд хүрээгүй Монгол Улсын иргэн;
 - 22.7.2 төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага, лиценз эзэмшдэг, төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэдэг аж ахуйн нэгж;
 - 22.7.3 шашны байгууллага;
 - 22.7.4 олон улсын байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн;

- 22.7.5 байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд;
 - 22.7.6 тодорхой нэр хаяггүй этгээд;
 - 22.7.7 дампуурсан болон банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд;
 - 22.7.8 Хуулиар хориглосон бусад этгээд.
- 22.8 Олон улсын байгууллага болон улс төрийн үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллага, сантай хамтран зохион байгуулах арга хэмжээ, хэрэгжүүлэх төслийн санхүүжилт энэ дүрмийн 22.7.4-т хамаарахгүй.

23 дугаар зүйл. Намын үйл ажиллагааг төлбөрийн чадварт нийцүүлэх

- 23.1 Намын бүх шатны хурлыг дан цахимаар, бүх гишүүд биечлэн оролцох, эсхүл цахим ба биечлэн оролцооны холимог хэлбэрийн аль бага өртөгтэй, нийтийн эрүүл мэндэд аюулгүй, оролцооны хувь өндөртэй байдлаар нь зохион байгуулна.
- 23.2 Намын гишүүний нэг жилийн татварыг түүний оршин байгаа бүс нутагт мөрдөгдөж буй нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хүртэл хувиар тогтооно.
- 23.3 Хөдөлмөрийн чадвараа 30 хувиас дээш хэмжээгээр алдсан бол гишүүний татварыг энэ Намын дүрмийн 23.2-т заасан дүнгийн 50 хувиар тооцно. Хөдөлмөрийн чадвар сэргээн тогтоосон бол энэ тухай мэдэгдэж нийтлэг дүнгээр татвараа төлнө.
- 23.4 Төрийн сонгуулийн жилд Үнэт Зүйлийн Хорооны саналаар аль нэг хурлыг ёслолын хэлбэртэйгээр зохион байгуулж болно. Зөвхөн ийм хуралд оролцох гишүүдийн хуралд ирэх, очих зардлыг намын хурлын төсвөөс санхүүжүүлнэ.
- 23.5 Намын сургалт, арга хэмжээ олонх гишүүдийн төлбөрийн чадварт нийцэхүйц төлбөртэй байж болно. Гишүүдийн олонхын төлбөрийн чадвараас давсан өндөр үнэтэй сургалт, арга хэмжээг намын нэрээр зохион байгуулахыг хориглоно.
- 23.6 Намын өдөр тутмын үйл ажиллагаа, бүртгэл, нийтийн зар, дотоод сонгууль, тандалт судалгаанд цахим технологи голлон ашиглана.

24 дугаар зүйл. Эрсдэлийн удирдлага, дотоод аудит, санхүүгийн тайлан

- 24.1 Намын үйл ажиллагаа, санхүүд Намын дарга, Ерөнхий менежер, Ажлын албан дахь Эрсдэлийн удирдлагын нэгж байнгын хяналт тавих ба Маргаан Таслах Комисс гишүүдийн гомдлын дагуу тус тус хяналт тавина.
- 24.2 Үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх механизм нь Эрсдэлийн Удирдлагын багийн (Дотоод аудитын хорооны) хуралдаан мөн. Энэхүү хуралдааныг Намын Дарга сар тутам зарлан хуралдуулж, хурлыг удирдана. Намын даргын эзгүйд Эрсдэлийн Удирдлагын багийн ээлжит хуралдааныг Ерөнхий менежер зарлан удирдана.
- 24.3 Энэхүү дүрмийн 24.2-т заасан хуралдаанд Намын дарга, Ерөнхий менежер, Намын Эрсдэлийн Удирдлагын газрын дарга, мэргэжилтэн, экспертүүд, хэлэлцэж буй асуудлаар мэргэшсэн хөндлөнгийн аудитор, шинжээч нар тус тус оролцоно.
- 24.4 Намын Ажлын Алба салбарын санхүүгийн тайлан гаргасны дараа нэгдсэн тайлан гаргана.

- 24.5 Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр хөндлөнгийн санхүүгийн аудит хийлгэж, аудитаас гарсан дүгнэлтийг нийтэд мэдээлнэ. Үүнд Монгол Улсын аудитын тухай хуулийг баримтална.
- 24.6 Намын хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, нээлттэй байх үүднээс шилэн данс хөтөлнө.
- 24.7 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн болон нөхөн сонгуулийн зардлын тайланг гаргахтай холбогдох харилцааг сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулна.
- 24.8 Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний хуримтлалын дансыг дотоод сонгууль болон төрийн сонгуулиас бусад хугацаанд битүүмжтэй байлгаж, зарлага гаргахгүй ба хуульд заасан хэмжээгээр, хуулиар хориглоогүй этгээдээс хандив авахад хяналт тавьж ажиллана.

25 дугаар зүйл. Нийтийн зар, хурлын ирц ба санал хураалтын горим

- 25.1 Энэ дүрэмд заасан намын хурал, дотоод сонгууль, намын аливаа шийдвэрийн төслийн хэлэлцүүлэг, намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалттай холбоотой үйл ажиллагааны аливаа зарыг нийтийн зар гэнэ. Намын доторх сонирхлын бүлгүүдийн уулзалт цугларалт, тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ зэрэгт хамаарах зар нь нийтийн зард тооцогдохгүй.
- 25.2 Нийтийн зарыг тухайн үйл ажиллагаанд нэр дэвших болон таслах эрхтэй бүх гишүүнд ижил арга хэрэгслээр, ижил хугацаанд түгээнэ.
- 25.3 Нийтийн зарыг түгээх үндсэн арга хэрэгсэл нь нийтлэг болон тусгай зар байна.
- 25.4 Нийтлэг зар гэж намын вэбсайт, фэйсбүүк хуудас болон намын цахим сүлжээний апп-аар дамжуулан хүргэсэн зарыг хэлнэ.
- 25.5 Тусгай зар гэж намын гишүүний ИОН намын цахим мэдээллийн сүлжээнд бүртгүүлсэн имэйл хаяг руу захидал бичих, утасны дугаарт мессеж илгээх, утсаар ярих, биечлэн уулзаж хүргэсэн зарыг тус тус хэлнэ.
- 25.6 Намын аливаа хурал, дотоод сонгуульд гишүүдийн оролцоог хангахын тулд нийтлэг болон тусгай зарыг хослуулан ашиглах ба нэг нийтийн зарыг дор хаяж нэг нийтлэг, нэг тусгай зарын арга хэрэгсэл ашиглан гишүүдэд хүргэнэ.
- 25.7 Гадаадад амьдарч буй гишүүнд тусгай зарыг зөвхөн имэйлээр хүргэнэ.
- 25.8 Энэ дүрмийн 25.6 болон 25.7 дахь заалтын дагуу нийтийн зарыг эрх бүхий гишүүдэд бүрэн хүргэсэн тохиолдолд аливаа хурлыг ирсэн ирцээр хуралдуулна. Ирсэн ирц гэж биечлэн танхимд ирсэн хүний тоо, цахимаар холбогдож оролцсон хүний тоо, намын албан ёсоор хэрэглэж буй цахим систем ашиглан саналаа өгсөн хүний тооны нийлбэрийг хэлнэ.
- 25.9 Энэ дүрмийн 25.8 дахь заалтад дурдагдсан ирцийн хэлбэрүүдийг тооцож хурлын дэгийг батална.
- 25.10 Хэрэв хуралд оролцвол зохих гишүүнд зар бүрэн хүргээгүй нь тогтоогдвол дараах арга хэмжээний аль нэгийг авна:

- 25.10.1 Хурлыг ирсэн ирцээр эхлүүлж, хурлын зарыг хүлээн авч чадаагүй гишүүдийн хаягийг тодруулж зөв болгохыг хурлаас Бүртгэгчид даалгасан тогтоол гаргах, эсхүл хурлын зар бүрэн хүрээгүй шалтгааныг нэг бүрчлэн дурдаж тэмдэглэл хөтлөн Намын менежерт хаяглан Эрсдэлийн удирдлагын хороогоор хэлэлцүүлэхээр хүргүүлэх;
- 25.10.2 Хурлыг нэг удаа хойшлуулж, зарыг бүрэн хүргэх арга хэмжээг авах;
- 25.11 Намын дотоод сонгууль, намын хурлын шийдвэрийн санал хураалт нь цахим систем ашиглан, цаасаар, гар өргөж саналаа өгөх гэсэн горимын аль нэгээр явагдана.
- 25.12 Хурлын шийдвэр, сонгуулийн үр дүн нь санал хураалтад оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар батлагдана.
- 25.13 Санал хураалт нь цахим систем ашиглах, цаасаар санал хураалт явуулах горимоор хэрэгжиж байгаа тохиолдолд уг санал хураалтыг зохион байгуулж буй этгээд санал хураалтад оролцох эрх бүхий гишүүдэд саналаа урьдчилж өгөх боломж гаргана.
- 25.14 Энэ дүрмийн 25.13-т заасан урьдчилсан санал хураалт нь дотоод сонгууль, хурлын товлосон хугацаанаас 72 цаг хүртэлх хугацааны өмнө эхэлж, санал хураалт хаах хүртэл үргэлжилж болно.

26 дугаар зүйл. Намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр намтай нэгдэх

- 26.1 Намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр намтай нэгдэх тухай асуудлыг намын бүртгэлтэй гишүүдийн 10 хувиас доошгүй нь гарын үсэг зурж шаардсаны дагуу хуралдсан Намын Их Хурлын төлөөлөгчдийн тавны дөрвийн саналаар шийднэ.
- 26.2 Нам нь үзэл баримтлал, үнэт зүйлийн давхцалын хувьд наян хувьд, дотоод ардчилал ил тод байдал нь ижил түвшинд, эсхүл ИОНН-аас илүү түвшинд хүрээгүй өөр намтай нэгдэхгүй. Хэрэв ингэж нэгдэх нөхцөл байдал үүсвэл намын нэр, болон оюуны өмчийн асуудлыг нэгдэл албажихаас өмнө тус намтай (намуудтай) гэрээ байгуулж шийднэ.

27 дугаар зүйл. Дүрэм хүчин төгөлдөр болох

- 27.1 Хуульд өөрчлөлт орсноор намын дүрмийн заалтыг хэрэгжүүлэх боломжгүй, хүчингүй болсон тохиолдолд тухайн заалтыг хуульд өөрчлөлт орсон өдрөөр хүчингүйд тооцно.
- 27.2 Энэхүү Намын дүрэм, холбогдох хууль тогтоомжид зааснаар Намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр бус байж ямар ч үйлчлэл үзүүлэхгүй.
- 27.3 Энэхүү Намын дүрэм нь ИОНН-ын гишүүд, дэмжигчдийн бүрэн ойлголцол, тохиролцоог илэрхийлэх бөгөөд урьдын бүх аман болон бичгийн хэлэлцээг орлох эцсийн цор ганц Намын дүрэм байна.
- 27.4 Энэхүү Дүрмийг Монгол хэлээр 2 эх хувь үйлдэж, нэг хувийг Монгол Улсын Дээд шүүхэд хадгалуулав.
- 27.5 Дүрмийн нэг эх хувийг Дээд шүүхэд бүртгэсний дараа нөгөө эх хувиас уйгуржин монгол бичигт хөрвүүлэх, баррель үсгээр хэвлэх, сонсдог эх хувь бэлтгэх, англи хэл рүү орчуулах ажлыг тус тус Намын Ажлын Алба хариуцаж зохион байгуулна.
- 27.6 Энэхүү дүрэм нь Үүсгэн байгуулах хурлаар батлагдсан цагаас эхлэн хүчин төгөлдөр болно